МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

# ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,

# САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ОДБААТАРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024он

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Б.ОДБААТАРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **"ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ"** | | | | | | |
| **НЭГ. "ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА, ТӨЛӨВЛӨЛТ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1:** Салбарын хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгцээ шаардлагыг судлан төслийн санал боловсруулан танилцуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана | - саналын тоо,<br>- шийдвэрийн төслийн тоо | - | эрх зүйн баримт бичгийн төсөл-1<br>Шийдвэрийн төсөл-1 | Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.04.30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан "Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсэг"-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж, Ажлын хэсгийн ажиллах нөхцөлөөр хангах, холбогдох судалгаа, статистик тоо баримтаар ханган, ажлын хэсэгт санал өгч ажиллан, ажлын хэсгээс гарсан баримт бичгийг нэгтгэх, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудыг нэгтгэн томьёолох, баримт бичгийн бүрдлийг хангуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох газраас санал авах, зөвшилцөх, өргөн барихтай холбоотой албан бичгүүдийн төслийг бэлтгэн холбогдох газруудад хүргүүлж ажилласан. Тус ажлын хүрээнд боловсруулсан "Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль"-ийн төсөл Засгын газар, Улсын Их хуралд өргөн барьж, Эдийн засгийн байнгын хороогоор 2024.05.28- | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдөр хэлэлцэн дэмжигдэн УИХ-аар хэлэлцэх эсэх талаар нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдэж анхны хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангуулахаар УИХ-аас байгуулсан ажлын хэсэгт шилжүүлсэн.<br>УИХ ээлжит сонгууль болж хуулийн төслийг ЗГ-т буцаасан.<br>ЗГ-ын 2024.08.14-ний өдрийн хуралдаанаар Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэнтэй холбоотойгоор Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд санал авч ТНБД-ын тушаалын төсөл, ажлын хэсгийн ажиллах удирдамжыг боловсруулан 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлуулсан. | |
| 2 | **Арга хэмжээ 1.2:**<br>Иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцжуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд, зорилтот бүлгийн шаардлагатай уялдуулан зохион байгуулах; | Судалгаа 2, Орон сууцны мэдээлэл 2, | - | - Орон нутгийн дэд бүтцийн бэлэн байдлын судалгаа 1<br>(ЕТ, ИДБ, Төсөл хэрэгжих боломжтой нөөц газар)<br>-Орон нутагт хэрэгжиж байгаа орон сууцны төсөл, арга хэмжээний мэдээллийг цуглуулан нэгтгэн гаргасан байна. | 21 аймгийн хэмжээнд ерөнхий төлөвлөгөөтэй суурин газруудын судалгаа мэдээллийг цуглуулан, ерөнхий төлөвлөгөөнд барилгажихаар тусгагдсан орон сууцны хангамжийн тоон мэдээллийг одоо байгаа орон сууцны мэдээлэл, иненерийн дэд бүтцийн хангамжийн бэлэн байдалтай суурин газруудаар боловсруулалт хийж үр дүнг гаргасан. Үүнд 330 сумын хэмжээнд 89 суурин газар ерөнхий төлөвлөгөөтэй, 116 суурин газар инженерийн төвлөрсөн шугам сүлжээтэй, байгаа бөгөөд одоо байгаа 76401 /2020 он/ айлын нийтийн зориулалттай орон сууцтай, төлөвлөлтөөр нийт 139562 айлын орон сууц төлөвлөгдсөн бөгөөд ИШС-ний бүрэн хангамжтай, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй 77 суурин газар байна.<br>Дэд бүтцийн нэгдсэн ИШС-тэй, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй аймаг, сумын төв, суурин газруудын судалгааг холбогдох байгууллага, орон нутгаас авч орон зайн болон статистик тоон судалгаа | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **УИХ 2023 оны 93 дугаар тогтоол-1.1** | | | -Орон нутаг дахь төрийн албан хаагчдын ерөнхий мэдээлэл гаргах<br>-Орон нутагт орон сууцны төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой байршлын мэдээллийг гаргасан байна. | хийж жагсаалт гаргасан. Жагсаалтаар засаг захиргааны нэгжийн хувьд 330 сум, Улаанбаатарын алслагдсан 3 дүүргээс төвлөрсөн ИШС-ний дэд бүтэцтэй, хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй 115 сум, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн нийт 118 суурин газар байна.<br>21 аймагт орон нутгийн захиалгаар улс орон нутаг, гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төслүүд, орон нутгийн төрийн төрийн байгууллагуудын орон сууцны зориулалттай эзэмшиж байгаа газруудын мэдээллийг орон нутаг болон, газрын нэгдмэл сангийн цахим системээр ламжуулан цуглуулж нэгтгэсэн.<br>Улсын магадлалаар хянагдаж баригдсан Дорноговь аймгийн захиалгаар хийгдсэн 8 айлын, Өмнөговь аймгийн захиалгаар хийгдсэн 10 айлын орон сууцны барилгын зураг төслийн загвар зургийг БХТ-ийн 2024.05.01-ний 1/1108 тоот албан бичгээр хүлээн авсан.<br>Говь-Алтай аймагт орон нутгийн захиалгаар зохиогдон, улсын магадлал хийгдсэн 15 айлын орон сууцны барилгын загвар зургийг аймгийн Ерөнхий архитекторoос ирүүлсэн. | |
| 3. | **Арга хэмжээ 1.3:**<br>Орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн орон сууцжуулах сайн туршлагыг судлах. | Санал-1 | - | - Орон нутагт хэрэгжүүлэх орон сууцжуулалтын сайн хувилбарыг судлан танилцуулсан байна. | 1. ТНБД-ын 2024.10.17-ны өдөр баталсан удирдамжын дагуу аймаг орон нутагт 2024.10.21-25-ны өдрүүдэд ажиллан, сумдын ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилт, орон сууцжуулах үйл ажиллагаатай хийгдэж байгаа сайн туршлагуудтай танилцан санал боловсруулан тайлангаар танилцуулсан. Үүнд онцлох сайн туршлагад:<br>- Аймгийн төвүүдэд шинэ орон сууцны хороолол байгуулахаар улсын төсвөөр гадна инженерийн шугам сүлжээний угсралт хийсэн газарт орон сууцжуулалтын талаар зорилтод арга хэмжээг авах, орон сууцны үнийг | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтвортой барих зорилгоор орон сууцны зориулалттай зарим газрыг орон нутгийн нэр дээр газар эзэмших эрхийг авсан,<br>- Шинэ орон сууцны хорооллын нам давхрын, эдлэн газартай амины сууцны бүсэд Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасныг удирдлага болгон амины орон сууцны зураг төслийг батлуулсны үндсэн дээр барилгажуулах нөхцөлийг газар эзэмшигч, өмчлөгчид тавьсан,<br>- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төвийн нийтийн аж ахуйн асуудлыг хариуцсан тусгай зөвшөөрөл бүхий орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулж, төвийн гадна инженерийн шугам сүлжээнд иргэн ААН-ын барилга, байгууламжийг холбох ажлыг шуурхай шийдвэрлэж, зардал багатайгаар холбох ажлыг хийж гүйцэтгэн, ач холбогдолыг олон нийтэд сурталчилах ажил хийсэн орон нутгийн сайн туршлага бүхий давуу талууд байна.<br>2. Орон нутгуудад орон сууцжуулалттай холбоотой хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны судалгаагаар дараах ололттой, сайн туршлагууд байна. Үүнд:<br>- Зарим аймгууд орон нутгийн орон сууцжуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ОНӨҮГ-ыг байгуулан түүгээр дамжуулан орон сууц барих ажлыг гадаад дотоодын хөрөнгө оруулагч, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байгаа,<br>- Алслагдсан сум, суурин газруудад төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор төрийн албан хаагчийн хэрэгцээ бүхий сумын төвүүдэд төрийн албан хаагчын орон сууцны зориулалтаар орон нутгийн мэдэлд газрын шийдвэр гаргуулсан, 8, 10 айлын орон сууцны барилгын зураг төсөл боловсруулж улс орон нутгийн төсвийн санхүүжилтээр барьж байгуулсан, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Зарим аймагт орон сууцны төсөл арга хэмжээг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран зохион байгуулахаар төсөл зарласан, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан, төлөвлөлтийн болон барилга, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулж байгаа,<br>Дорноговь, Өмнөговь аймгууд түрээсийн орон сууцны санг бий болгох зорилгоор улс, орон нутгийн төсөвт санхүүжилтийн хөрөнгө суулган зах зээл дээр борлогдож байгаа орон сууцнаас худалдан авалт хийх сонгон шалгаруулалт зарласан зэрэг сайн туршлагууд байна. 100% | |
| **ХОЁР. "ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ТООЦОО, СУДАЛГАА, СТРАТЕГИ, ХӨТӨЛБӨР, ДҮРЭМ, ЖУРМЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ;" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 2.1:**<br>"Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.<br>ЗГҮАХХҮТ 3.7.9.3<br>МУХОХ 36 | -Төслийн удирдах хорооны хуралд оролцох.<br><br>-Саналын тоо | Төслийн ТЭЗҮ-г боловсруулж, . зээлийн гэрээг байгуулан, зөвлөх үйлчилгээний багийг сонгон шалгаруулсан | Төслийн барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийг бүрдүүлэхэд ТОСК, төслийн зөвлөх багт дэмжлэг үзүүлж ажилласан байна | 2024.02.24-нд ТУХ-ны III хурал болж төслийн 2024 оны үйл ажиллагааны, санхүүгийн болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнүүдийг баталсан.<br>НЗД-ын 2024.01.10-ны А/20 захирамжаар байгуулагдсан "Төслийн барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо"-оос Төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шал-гаруулах тендерийг 2024.03.01-нд зарлаж, тендерт оролцогчдыг үнэлж эцсийн дүгнэлт гарган, тендерт шалгарсан Солонгос Улсын ILSUNG байгууллагатай НЗДТГ гэрээ байгуулах шатанд шилжсэн. | 100 |
| 5 | **Арга хэмжээ. 2.2.**<br>Эко яармаг-1 гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллана. | Төслийн хэрэгжилт, хувь | -Магадлалаар хянагдан дүгнэлт гарсан Төслийн шинэчилсэн иж бүрдэл зураг төсөл 1 /100%/ | Төслийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-ийг нэгдсэн удирдлага, | Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Наадамчдын зам дээгүүр барих 800у/м гүүрэн байгууламж төслийн талбайтай дахцаж байгаатай холбоотойгоор ТОСК, замын зураг төсөл боловсруулж байгаа байгууллага, Төслийн зураг төсөл боловсруулсан байгууллагыг холбон 2 удаагийн зөвшилцөх уулзалт хийж төслийн барилгажилтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан төслийг НАЗХГ-тай зөвшөөрөлцсөн бөгөөд нийслэлийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | МУХОХ 38 | | -Төслийн талбайг чөлөөлөх ажил 100%<br>-Ашиглалтад хүлээлгэн өгсөн цахилгааны дэд өртөө 1 | чиглэлээр хангаж, тухай бүр дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, төслийн явцын мэдээллийг нэгтгэн танилцуулсан байна | Ерөнхий архитектороор хянуулан баталгаажуулахаар хүргэгдсэн.<br>Төслийн төлөвлөлтийн дагуу гадна цахилгаан хангамжийн сүлжээний чиглэл, зурвас өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл дахин боловсруулагдсан. Эрчим хүчний яамнаас Цахилгаанаар хангах техникийн нөхцөл хүлээгдэж байна. | |
| 6 | **Арга хэмжээ 2.3:**<br>Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.<br><br>ЗГҮАХХҮТ 3.7.9.4 | -Төслийн удирдах хорооны хуралд оролцох.<br><br>-Саналын тоо | Баянхошуу дэд төвийн эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 45%,<br>Шархад дэд төвийн эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 30%,<br>Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээний угсралтын ажил 40%. | Барилга, хот байгуулалтын яамны зүгээс эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй орон сууц төлөвлөхөд дэмжлэг үзүүлж, Төслийн удирдах хорооны хуралд оролцож, удирдлага, арга зүйн чиглэлээр хангаж ажилласан байна. | УХ-ны 2024 оны I хуралдаан 2024.02.27-нд болж 2024 онд хэрэгжүүлэх нийт үйл ажилла-гаа, худалдан авах ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөг баталж, төслийн ажилтнуудын 2024 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгах, төслийн II бүрэлдэхүүнээр хэрэгжүүлэх эко хорооллуудын талбарыг тодорхойлох, ухаалаг удирдлагын нэгдсэн төвийг хөгжүүлэх асуудлуудыг хэлэлцэн хуралдааны тогтоол, зөвлөмж гарсан. 2024 оны нийт төсөв 151.8 тэрбум төгрөгөөр баталснаас СЯ-аас 52,3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан.<br>Баянхошуу дэд төвийн Б15 талбарын 110 айлын орон сууцны барилга угсралт 90%<br>Эхний ээлжийн 110 айлын орон сууцад зориулсан гадна ИШС-ний барилга угсралт бүрэн дуусч 2024.10.01-ний өдөр ашиглалтад хүлээн авах комисс зохион байгуулагдсан.<br>Баянхошуу дэд төвийн Б13-1 талбарт 2024 оны 7 сард эхэлсэн 150 айлын орон сууцны барилгын ажил 35%<br>Баянхошуу дэд төвийн Б13-2 талбарт 2024 оны 10 сард эхэлсэн 76 айлын орон сууцны барилгын ажил 10%<br>Шархад дэд төвийн S27-5 талбарын эхний ээлжийн 110 айлын орон сууцны барилгын ажил 85% | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шархад дэд төвийн лэл бүтцийн барилга байгууламжийн угсралтын ажлыг 2024 оны 7 сараас эхлүүлэн бүрэн дууссан.<br>Шархад дэд төвийн S27-2 талбарт баригдаж буй 152 айлын орон сууцны барилгын ажил 35%<br>Шархад дэд төвийн 2-аар ээлжийн 76 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаж, материал ирүүлсэн 4 аж ахуйн нэгжийн тендерийн баримт бичгийг үнэлэх ажил хийгдэж байна. | |
| 7 | **Арга хэмжээ 2.4:**<br>"Залуус-1" орон сууцны хороолол барих төслийг хэрэгжүүлнэ.<br><br>ЗГҮАХХҮТ 3.7.9.7<br>ШСБҮАХХХТЖ 17<br>МУХТ 6.2.1.1. | -Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэл; | -Дулааны шугам сүлжээний ажил 65%, Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажил 60%, Хонгилын системийн угсралтын ажил 68%, Цахилгаан хангамжийн угсралтын ажил 65% | Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлыг батлагдсан төсвийн хүрээнд бүрэн хэрэгжсэн байна. | Төслийн шугам сүлжээний угсралттай холбоотой ажлуудыг НААИДББХЗГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан.<br>ИШС-ний угсралтыг үргэлжлүүлэх ажил 2024 оны улсын төсөвт батлагдсан 12.7 тэр бум төгрөгийн хүрээнд 2024.03.25-аас эхэлсэн. Гадна дулааны шугам сүлжээ байгууламжийг "Одкон холдин" ХХК 95% гүйцэтгэлтэй барилгын ажлыг хийж 2024.11.10-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн.<br>Хорооллын гадна инженерийн шугам сүлжээний хонгилын системийн барилга угсралт "Биг монгоиа бюлдинг" ХХК 70%-ийн гүйцэтгэлтэй хийж 2024.10.10-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн.<br>Төслийн гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний барилга байгууламжийн угсралтыг 75%-ийн гүйцэтгэлтэйгээр "Өи Эс Би Инержи" ХХК гүйцэтгэн 2024.11.15-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн.<br>"Алтайн үндэс" ХХК төслийн гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний барилгын ажлыг 100% хийж гүйцэтгэсэн. Усны насосны үнэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор насос сонгох ажлыг Ус сувгийн удирдах газартай зөвшилцөх ажил хийгдэж байна. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Залуус-1” орон сууцны хороолол барих төслийн хүрээнд баригдах Дулааны цахилгаан станцын барилгын ажлын зураг төсөлд “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ хамтран магдалал хийсэн. | |
| 8 | **Арга хэмжээ 2.5:** Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий "Амины орон сууц"-ны загвар төсөл, материал, тоног төхөөрөмжийг олон нийтэд сурталчлах, иргэдэд хямд үнээр амины орон сууц барих талаар мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг чиг үүрэг бүхий “/ЧД, СХД, СБД, БГД- т Технологи дамжуулах төв”-ийг байгуулах ажлыг зохион байгуулах. | Санал-1 | | Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд “технологи дамжуулах төв”-ийг байгуулах боломжтой газрын судалгаа хийж Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгсөн байна | Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нам давхрын, амины орон сууцны, эдлэн газартай амины сууцны болон гэр хорооллын бүсээр тодорхойлогдсон газруудад “амины орон сууцны технологи дамжуудах төв”-ийг байршуулах боломжтой газрын судалгааг үндэсний орон зайн мэдээллийн цахим системийн Газрын мэдээллийн egazar,gov,mn систем, нийслэлийн барилгын нэгдсэн цахим urban.ub.gov.mn системээр дамжуулан орон зайн дүн шинжилгээ хийн сонгосон байршлуудад “Технологи дамжуулах” төвийн зориулалттай газрыг сонгон ХББОСЯ-ны нэр дээр газар эзэмших хүсэлтийг НЗД, НГЗА-нд 03/635 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Нийслэл Улаанбаатар хотын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ЧД, СХД, СБД, БГД-т “Технологи дамжуулах төв”-ийн зориулалтаар газрын байршлыг тодорхойлон санал өгсөн.<br>“Технологи дамжуулах төв” -ийг Улаанбаатар хотын СД, ЧД, СХД, БЗД-үүдийн нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх баг сонгон шалгаруулалтыг 2024.11.06-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зарласан.<br>Тендер шалгаруулалтаар сонгон шалгарсан Монголын амины орон сууцны инноваци хөгжлийн төв “Амины орон сууцны мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг 2024.12.18-нд үйл ажиллагаагаа эхлүүлсэн | 100 |
| 9 | **Арга хэмжээ 2.6:** | Судалгаа-1 | - | - Түрээсийн орон сууцны төсөл | “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Зарим сумдад загвар түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх. | | | хэрэгжүүлэх боломжтой газруудын судалгааг хийж танилцуулсан байна. | хэмжээний тухай” УИХ-ын 2023 оны 93 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын 1.1, “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2023 оны 483 дугаар тогтоолын 2.10-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл хэрэгжүүлэх боломжтой инженерийн хангамжийн нэгдсэн шугам сүлжээ бүхий аймгийн төвөөс бусад 92 сумын төв, суурин газрын жаг-саалтыг гарган СЯ-нд 2024.05.03-ны 01/1450 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны бүсэд хамаарах, төрийн байгууллагын мэдэлд байгаа Түрээсийн орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэх боломжтой орон сууцны зориулалттай газруудын мэдээллийг цуглуулж гаргасан.<br>Цуглуулсан мэдээллээр 12 аймгийн 36 суманд нийт 61 байршил төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр орон сууцны зориулалттай газар байна.<br>Улаанбаатар хотоос шилжин суурьших боломжтой төрийн албан хаагчдын ойролцоо мэдээлэл бүрдүүлэх зорилгоор 21 аймагт ажиллаж байгаа төрийн албан хаагчид /ТЗ, ТҮ, ТТ/-ын ажилласан жилийн болон шаардлагатай байгаа орон тооны мэдээллийг цуглуулсан. 2024.10.15-ны мэдээллээр 21 аймагт Төрийн захиргааны 11386, Төрийн тусгайн 1379, Төрийн үйлчилгээний 86210, нийт 98972 албан хаагч ажиллаж, Төрийн захиргааны 3828, Төрийн үйлчилгээ /захирал, эрхлэгч/-ний 86 нийт 3914 сул ажлын байр байсан байна.<br>Аймаг, сумын төвд барих боломжтой улс, орон нутгийн төсвөөр боловсруулсан төрийн албан хаагчдын орон сууцны барилгын магадлалаар хянагдсан зургуудийн мэдээлэл цуглуулсан. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үүнд Говь-Алтай аймгийн захиалгаар хийгдсэн 15 айлын, Өмнөговь аймгийн захиалгаар хийгдсэн 10 айлын, Дорноговь аймгийн захиалгаар хийгдсэн 8 айлын орон сууцны барилгын зураг төсөл 2024 онд улсын магадлалаар хянагдан баталгаажсан байна.<br>Орон нутгийн хөгжлийн төвөөр тогтоосон 91 сумын төв, суурин газруудаас 10 сумдын төвд орон нутгийн засаг, захиргаатай хамтран төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг 2024.10.29-нд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зарласан. | |
| **ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | |
| 10 | **Арга хэмжээ 3.1:**<br>Орон сууцны хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг цуглуулж нэгтгэн тайлагнаж ажиласан байна. | | | -Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны барилгуудын мэдээллийг цуглуулан нэгтгэсэн байна<br>-Салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг тухай бүр гарган, холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан байна. | “150 000 айлын орон сууц” хөтөлбөрийн 2023 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж ХШДАГ-т хүргүүлсэн.<br>Улсын хэмжээнд 2023 онд шинээр ашиглалтад орсон орон сууцны мэдээ, 2024 онд үргэлжлэн баригдах орон сууцны төсөл хөтөлбөрийн мэдээллийг нэгтгэн боловсруулж МонголБанкинд хүргүүлсэн.<br>“Нийслэл Улаанбаа-тар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны богино болон дунд хугацааны төлөвлөгөө”-ний “хот төлөвлөлт, оновчтой зохион байгуулалтыг сайжруулах” зорилгын хүрээнд гүйцэтгэсэн ажлын мэдээг нэгтгэн боловсруулж 2024.03.21-ны 01/864 дугаартай албан бичгээр НУХАЗТБҮХ-нд хүргүүлсэн.<br>Солонго төслийн хүрээнд барилгажилтын талбайн нөлөөлөлд өртсөн 303 дугаар ангийн тусгай үүргийн зориулалтын замын трассын асууд-лаар холбогдох байгуул-лагуудын төлөөллийг оролцуулсан уулзалтыг 3 удаа зохион байгуулж холбогдох чиглэлүүдийг өгч ажилласан. БХЯ-аас ЗГ-ын 2019 оны 440 дугаар тогтоолоор баталсан “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газрын хориотой бүс тогтоох журам"-ыг авч судлан санал боловсруулан ББТҮБХЗГ-т өгсөн.<br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон нийслэл хотод хэрэгжиж байгаа Залуус-1, Солонго-1, 2, Баянголын ам, ЭКО-Яармаг-1, Орлгод нийцсэн орон 10000 орон сууцны эко хороолол төслүүдийн мэдээллийг хагас, бүтэн жилээр гарган тайлагнасан.<br>Орон нутгийн хэмжээнд хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа орон сууцны барилгын ажлын мэдээлдийг цуглуулан нэгдсэн тоон мэдээллийг гаргасан. Мэдээллээр 2024 онд 21 аймагт барилгын ажил явагдаж байгаа 18268 айлын орон сууцны барилга байна.<br>2023 оны жилийн эцсийн, 2024 оны хагас жилийн ашиглалтад оруулсан орон сууцны барилгын статистик мэдээн дээр боловсруулалт хийж Улаанбаатар, 21 аймгийн хэмжээнд ашиглалтад орсон дүнг нэгтгэн гаргаж танилцуулан, холбогдох газруудад хүргүүлсэн. | |
| 11 | **Арга хэмжээ 3.2:**<br>Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | Саналын тоо | Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч ажилласан. | Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. | - ИНЕГ-ын боловс-руулсан "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэр-гийлэх журам"-ын төсөлд 4 санал боловсруулан 2024.02.23-ны 05/562 дугаар албан бичгээр ИНЕГ-т,<br>- "Хүн ам орон сууцны завсрын тооллогын хороо байгуулах тухай" тушаа-лын төсөлд 2 санал бэлтгэн 2024.01.18-ны 01/174 дугаар албан бигээр ҮСХороонд тус тус хүргүүлсэн.<br>Тайлант жилийн хугацаанд дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас ирүүлсэн 2 хуулийн төсөл, 4 Засгийн газрын тогтоол, дүрэм журмын төсөлд санал өгч ажилласан. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | **Арга хэмжээ 3.3:** Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | Мэдээ, мэдээлэл | Шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр бэлтгэн, хүргэж ажилласан | Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг салбарын үнэн зөв, бодит мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна. | 2023 онд ашиглалтад орсон орон сууцны барилга байгууламжийн мэдээллийг нэгтгэн улсын хэмжээнд ашиг-лаж байгаа нийтийн зориулалттай орон сууцны тоон мэдээл-лийг гарган мэдээллийн санг үүсгэсэн. Улсын хэмжээнд 2024.1.1-ний байдлаар 19196 айлын орон сууцны барилга ашиглалтад орж, улсын хэмжээнд нийт 411101 айлын орон сууц ашиглагдаж байна.<br>Зах зээлд борлогдож байгаа орон сууцны мэдээллийг нэгтгэн мэдээллийн сангийн бааз үүсэгсэн. Үүнд 2024.04.30-ны өдрийн байдлаар шинээр ашиг-лалтад орсон 19196 айлын, ашиглагдаж байгаа 9876, нийт 29072 айлын орон сууц захиалга авч байсан байна.<br>“Үндэсний баялагийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо”, “Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”, “Сангийн яам” зэрэг төрийн байгууллага, Монголбанк, 3 төрийн бус байгууллагад мэдээлэл авахаар илгээсэн маягтын дагуу мэдээлэл цуглуулан боловсруулалт хийж тус тус албан бичгээр болон харилцах цахим шуудангаар хүргүүлсэн байна. | 100 |
| 13 | **Арга хэмжээ 3.4:** Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | Ёс зүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна. | - | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн хүрээнд ажилласан байна. | Хууль тогтоомжид заасан хугацаанд ХАСХОМ-ийг тайлагнасан. | 100 |
| 14 | **Арга хэмжээ 3.5:** Хэлтсийн хариуцах чиг үүргийн хүрээнд холбогдох тушаал, | Гүйцэтгэл | -150 000<br>-шинэ сэргэлт | Тухай бүр шаардлагатай мэдээллийг хугацаанд нь | 1. “150 000 айлын орон сууц” хөтөлбөрийн 2023 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж ХШДАГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэр, бодлогын баримт бичигт туссан асуудлын биелэлт, төлөвлөлтийг тухай бүр хугацаанд нь боловсруулж, тайлагнаж ажиллах. | | -ЕС-ын албан даалгавар<br>-Гүйцэтгэлийн төлөвлөгөө<br>-3% | тайлагнаж ажилласан байна. | 2. Улсын хэмжээнд 2023 онд шинээр ашиглалтад орсон орон сууцны мэдээ, 2024 онд үргэлжлэн баригдах орон сууцны төсөл хөтөлбөрийн мэдээ-лэлийг нэгтгэн боловс-руулж МонголБанкинд хүргүүлсэн.<br>3. “Нийслэл Улаанбаа-тар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны богино болон дунд хугацааны төлөвлөгөө”-ний “хот тө-лөвлөлт, оновчтой зохион байгуулалтыг сайжруу-лах” зорилгын хүрээнд гүйцэтгэсэн ажлын мэдээг нэгтгэн боловсруулж 2024.03.21-ны 01/864 дугаартай албан бичгээр НУХАЗТБҮХ-нд хүргүүлсэн.<br>4. Улсын хэмжээнд 2022, 2023 онд барилга байгууламжид оруулсан хөрөнгө оруулалт, 2024 оны төсөөлөл, хүчин чадлын тоон мэдээл-лийг нэгтгэн гаргаж Монголбанк-нд 2024.02.16-ны 05/492 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>5.Газрын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, хянуулан 2024 оны 1-р сард баталгаажуулсан. УИХ сонгууль болж, шинэ засгийн газар бүрэлдэн байгуулагдсантай холбоотойгоор газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дахин шинээр боловсруулсан.<br>6.Газрын хэмжээнд дотоод зохион байгуулалтын хүрээнд олгогдсон хариуцах ажлын хүрээнд:<br>- Ерөнхий сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийн тайланг,<br>- Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлсэн ажлын тайланг,<br>- Шинэ сэргэлтийн бодлого хөгжлийн дунд хугацааны баримт бичгийн хэрэгжилтийн тайланг,<br>- Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн тайланг тус тус нэгтгэн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулж ТЗУГ, ХШДАГ-т хугацаанд нь хүргүүлсэн | |
| 15 | **Арга хэмжээ 3.6:** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Өргөдөл, гомдол албан бичиг | - | Төрийн албаны үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | 2024 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар<br>- Нийт 56 албан бичгийн төсөл боловсруулан хянуулж 52 албан бичгийг явуулсан<br>- 128 албан бичиг хуваарьлагдан ирснээс хариутай 27 бичигнээс 23 бичгийг судлан хариу өгч 4 бичгийг судлан шийдвэрлэх шатандаа байна.<br>- 13 иргэний өргөдөл ирснээс 12 иргэний өргөдлийг шийдвэрлэн хариу өгч, 1 иргэний өргөдөлийг судлан хариу албан бичгийн төслийг боловсруулан хяналтын шатанд байна. | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-ийн хувь |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | **Арга хэмжээ 1.** Байгууллагаас зохион байгуулсан албан хаагчыг | Хамрагдсан сургалтын | - | 1 | Яамнаас зохион байгуулсан төрийн худалдан авах ажиллагааны АЗ | 2024.10.07 2024.10.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадавхижуулах сургалтад оролцох. | тоо, гэрчилгээ | | | сертификатын сургалтад хамрагдан шалгалт өгч тэнцсэн. | | |
| 2 | **Арга хэмжээ 2.**<br>Гадаад орны ижил төстэй үйл ажиллагааны талаар судалсан байна | Судалсан төслийн тоо, тайлан | - | 1 | БНХАУ-ын экологи, байгаль орчны яамны Сурталчилгаа, боловсролын төвийн зохион байгуулсан “Ногоон хөгжлийн бүс ба зам” гадаад тусламжийн чадавхийг дээшлүүлэх сургалтад<br>Гэрчилгээ № 24C4188003 | 2024.04.10<br>2024.04.25 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | | |
|---|---|---|---|
| СХОСБЗГ-ын ОСХ-ийн Орон сууцны хангамжийн судалгаа, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн | Б.Одбаатар | ............................ | 2024. .......... |
| *(Албан тушаал)* | *(Нэр)* | *(Гарын үсэг)* | *(Огноо)* |